

## ҮНЭТ ЭДЛЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

**Үнэт эдлэл гэдэг нь:** Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн гоёл чимэглэлийн зүйлсийг (бөгж, хүзүүний зүүлт, ээмэг, бугуйвч гэх мэт) хэлнэ.

**Эрдэнэсийн сангийн тухай хуульд зааснаар:**

"**үнэт металл**" – алт, мөнгө, платина болон түүний бүлэгт багтдаг палладий, иридий, родий, рутений, осмийг;



"**үнэт чулуу**" – доржпалам, бадмаараг, маргад эрдэнэ, индранил, сувдыг;



Үнэт эдлэлээ зөв сонгоход **карат /сорьц/** чухал үүрэгтэй байдаг

Жишээ болгон алтыг авч үзвэл **карат гэдэг нь** үнэт эдлэлийг хийхэд хичнээн хэмжээний алт орсныг хэмждэг нэгж юм.



Үнэт металлаар хийсэн эдлэл дээрх карат /k/-ын тэмдэглэгээ нь сорьц

24k– 99.9% сорьцтой буюу цэвэр алт;  
18k– 75% алт, 25% бусад металл гэх мэт.

Карат нь 2 утгыг агуулдаг



Үнэт чулуун дээрх карат /ct/-ын тэмдэглэгээ нь түүний жин

1ct– 200мг;  
0.5ct– 100мг-тай тэнцэх гэх мэт



## ҮНЭТ ЭДЛЭЛ ХУДАЛДАН АВАХДАА АНХААРАХ ЗӨВЛӨМЖ

### Үйлдвэрлэгчийн барааны тэмдэг, улсын сорьцын баталгааг шалгах

дээрх тэмдгүүд нь мэдэгдэхгүй, балархай, цифрүүдийн шрифтийн хэмжээ харилцан адилгүй зэрэг эдлэлийг хийсэн металл нь үнэт металл биш байх магадлалтай.



### Үнэт эдлэлийг таних хамгийн энгийн арга нь үнэ юм

үнэт чулуун шигтгээтэй алт, мөнгөн эдлэл нь их өндөр үнэтэй байх бөгөөд хямд байвал үнэт эдлэл биш гэж ойлгож болно.




### Үнэт эдлэлийн жин, чулуун шигтгээ зэргийг шалгуулах

эдлэлийн нэр, сорьц, жин, чулуун шигтгээний нэр, байгалийн, таримал, дуураймал аль нь болох, карат зэргийг бичүүлсэн гэрчилгээг авах.



Санхүүгийн зохицуулах хорооны 2020.03.25–ний өдрийн 150 дугаар тогтоолоор “**Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох тухай журам**” батлагдсан.

Та дараах QR кодыг уншуулж худалдан авалт хийх гэж буй газар тань тусгай зөвшөөрөлтэй эсэхийг шалгах боломжтой.



Тусгай зөвшөөрөлтэй гэдэг нь **баталгаатай гэсэн үг биш** бөгөөд та хариуцлагаа өөрөө хүлээх тул сайтар нягталж сонголтоо хийгээрэй.